



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/194

Мандалговь

Хөдөө аж ахуйн салбар болон төв,
суурин газрын 2020-2021 оны өвөлжилт,
хаваржилтын бэлтгэл хангах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а" дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Хөдөө аж ахуйн салбар болон төв, суурин газрын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах зарим арга хэмжээний тухай" аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 03 тоот албан даалгавар, 2020-2021 оны аймгийн Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, ажлын явцад хяналт тавих, хэрэгжилтийг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

Хоёр. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2020 оны 10 дугаар сарын 5-ны дотор хангаж, тайлан мэдээг 10 дугаар сарын 12-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэх, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний дотор хангаж, тайланг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга, харьяа газар, хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Засгийн газрын тогтоол, албан даалгаврыг хэрэгжүүлэх, ажил зохион байгуулах, ажлын явцад хяналт тавих, шалгуур үзүүлэлтийн дагуу хүлээн авах ажлыг 10 дугаар сарын 19-ны өдрийн дотор зохион байгуулж, дүн мэдээг 10 дугаар сарын 26-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг (Ж.Мөнхчулуун)- т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010546

Аймгийн Засаг даргын 2020 оны 08
сарын 03-ний өдрийн А/194 тоот
захирамжийн хоёрдугаар хавсралт

Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Ж.Мөнхчулуун (Аймгийн Засаг даргын орлогч)
- Нарийн бичгийн дарга: Н.Эрдэнэ-Очир (Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
- Гишүүд:
- О.Мөнхзул (Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
 - М.Адъяабаатар (Онцгой байдлын газрын дарга)
 - Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
 - Г.Бат-Орших (Эрүүл мэндийн газрын дарга)
 - Б.Золжаргал (Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)
 - А.Мөнхтуяа (Боловсрол, соёл, урлагийн газрын даргын түр орлон гүйцэтгэгч)
 - Д.Ганбаатар ("Дундговь-Ус" ОНӨҮГ-ын захирал)
 - Ц.Бямбацогт (Автотээврийн төвийн дарга)
 - Х.Анхбаяр (Сайнцагаан сумын Хот тохижуулах газрын дарга)
 - С.Намжилцэрэн (Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын дарга)
 - Б.Мягмарсүрэн (Багануур зүүн өмнөд бүсийн ТӨХК-ийн Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга)
 - А.Гантулга ("Авто замын машин механизм" ХХК-ийн гүйцэтгэх захирал)
 - Б.Бямбасүрэн (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)